АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

# Архангай аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2026/035/НА-ТА-ТШ3**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.open.audit.mn<br><br>Архангай аймаг<br>2026 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br>Аудитор А.Пүрэвцэцэг<br>Утас: 99746363<br>Цахим хаяг: Purevtsetsega@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**


**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn


2026.02.25 № 102

танай ____________-ны №____________-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ХҮҮХЭД ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Г.ОЮУННАРАН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Аудитын гол асуудал**

Тайлангийн жилд тус байгууллага нь улсын төсвөөс 1,984,251.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 91.2 хувь буюу 1,810,881.8 мянган төгрөгийг зарцуулж 173,004.8 мянган төгрөгийг хэмнэн ажилласан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 4 үндсэн зорилтын хүрээнд 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна. Тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газраас 97.9 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Данс | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **121,548,413.94** | **127,813,862.00** |
| **354** | **Хангамжийн материал** | **121,548,413.94** | **127,813,862.00** |
| 3541 | Бичиг хэргийн материал | 9,861,240.00 | 9,826,675.00 |
| 3542 | Аж ахуйн материал | 109,005,449.94 | 114,315,963.00 |
| 3545 | Барилгын засварын материал | 2,681,724.00 | 3,671,224.00 |
| **I** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **121,548,413.94** | **127,813,862.00** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **852,940,637.89** | **858,819,211.67** |
| **392** | **Биет хөрөнгө** | **814,688,554.56** | **822,742,128.46** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 708,826,630.17 | 726,478,082.17 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -134,154,859.42 | -158,756,207.14 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 63,500,000.00 | 77,596,705.97 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -57,520,833.27 | -64,087,362.75 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 180,966,356.00 | 237,703,256.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -64,292,125.96 | -103,550,437.34 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 85,488,796.27 | 91,176,556.27 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -37,705,336.81 | -47,413,300.26 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 93,589,288.00 | 93,589,288.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -26,226,860.42 | -32,211,952.46 |
| 39217 | Ном | 2,217,500.00 | 2,217,500.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **38,252,083.33** | **36,077,083.21** |
| 39301 | Програм хангамж | 7,700,000.00 | 7,700,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -3,887,916.67 | -6,062,916.79 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 34,440,000.00 | 34,440,000.00 |
| II | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 852,940,637.89 | 858,819,211.67 |
| III | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 974,489,051.83 | 986,633,073.67 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | 558,155.00 |
| 413 | Өглөг | | 558,155.00 |
| 4136 | Бусад өглөг | | 558,155.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | | 558,155.00 |
| **IV** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | **558,155.00** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **974,489,051.83** | **986,074,918.67** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 324,360,727.09 | 324,360,727.09 |
| 51101 | Өмч: - төрийн | 324,360,727.09 | 324,360,727.09 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **441,660,794.34** | **453,246,661.18** |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | 441,660,794.34 | 441,660,794.34 |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | 11,585,866.84 |
| **513** | **Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү** | **208,467,530.40** | **208,467,530.40** |
| **V** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **974,489,051.83** | **986,074,918.67** |
| **VI** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **974,489,051.83** | **986,633,073.67** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,200,837,162.70** | **2,114,455,592.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,039,125,600.00** | **1,934,103,900.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,039,125,600.00 | 1,934,103,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **161,711,562.70** | **180,351,692.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 29,293,902.70 | |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 70,680,000.00 | 129,532,200.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 61,737,660.00 | 50,819,492.00 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **399,747,529.00** | **97,220,155.22** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **399,747,529.00** | **97,220,155.22** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 77,270,600.00 | 5,364,700.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 307,926,929.00 | 91,215,455.22 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 14,550,000.00 | 640,000.00 |
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,600,584,691.70** | **2,211,675,747.22** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,318,860,482.81** | **2,200,089,880.38** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,267,130,362.25** | **2,069,483,060.42** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **587,227,730.00** | **1,325,942,050.00** |
| 210101 | Үндсэн цалин | 345,701,926.00 | 761,840,458.00 |
| 210102 | Нэмэгдэл | 184,029,804.00 | 330,023,968.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 13,159,000.00 | 137,260,751.00 |
| 210104 | Урамшуулал | 44,337,000.00 | 96,816,873.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **73,186,303.00** | **171,534,316.50** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 49,766,840.95 | 118,369,756.82 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,854,915.13 | 13,391,352.67 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,927,407.63 | 6,503,006.91 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,927,407.63 | 6,627,519.83 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,709,731.66 | 26,642,680.27 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **72,415,744.14** | **75,763,192.84** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,690,222.00 | 11,544,947.00 |
| 210302 | Түлш, халаалт | 54,910,230.00 | 56,830,232.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,815,292.14 | 7,388,013.34 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **35,589,495.00** | **15,383,828.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 4,421,920.00 | 2,787,045.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,598,532.00 | 8,842,373.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,406,906.00 | 2,669,460.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,407,160.00 | 385,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,414,423.00 | 699,950.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 14,340,554.00 | |
| **2105** | **Нормативт зардал** | **30,171,526.00** | **27,012,601.50** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 4,294,850.00 |
| 210502 | Хоол, хүнс | 30,171,526.00 | 11,358,251.50 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | 11,359,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **13,961,825.00** | **8,474,980.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 16,500.00 | 200,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 13,945,325.00 | 8,274,980.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **167,700.00** | **20,637,240.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 167,700.00 | 20,637,240.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **330,224,227.00** | **273,033,830.14** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 329,529,767.00 | 268,923,390.14 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 242,400.00 | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 133,400.00 | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 56,500.00 | 143,300.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 40,400.00 | 44,080.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 197,560.00 | 2,386,005.00 |
| 210807 | Газрын төлбөр | 24,200.00 | 1,537,055.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **124,185,812.11** | **151,701,021.44** |

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,330,000.00 | 63,994,140.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 120,855,812.11 | 87,706,881.44 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **51,730,120.56** | **130,606,819.96** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **31,973,477.00** | **7,384,800.00** |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 30,503,477.00 | 3,910,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,470,000.00 | 3,474,000.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **19,756,643.56** | **123,222,019.96** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 19,756,643.56 | 123,222,019.96 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,318,860,482.81** | **2,200,089,880.38** |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **281,724,208.89** | **11,585,866.84** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **404,791,509.79** | |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 371,746,452.29 | |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 33,045,057.50 | |
| **IV** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **-404,791,509.79** | |
| **V** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-123,067,300.90** | **11,585,866.84** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,278,107,762.70** | **2,119,820,292.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **77,270,600.00** | **5,364,700.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **77,270,600.00** | **5,364,700.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 77,270,600.00 | 5,364,700.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,200,837,162.70** | **2,114,455,592.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,039,125,600.00** | **1,934,103,900.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,039,125,600.00 | 1,934,103,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **161,711,562.70** | **180,351,692.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 29,293,902.70 | |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 70,680,000.00 | 129,532,200.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 61,737,660.00 | 50,819,492.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,234,043,360.70** | **2,117,450,292.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,234,043,360.70** | **2,117,450,292.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,182,313,240.14** | **1,986,843,472.04** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **587,227,730.00** | **1,239,621,309.00** |
| 210101 | Үндсэн цалин | 345,701,926.00 | 677,417,977.00 |
| 210102 | Нэмэгдэл | 184,029,804.00 | 328,674,141.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 13,159,000.00 | 136,869,000.00 |
| 210104 | Урамшуулал | 44,337,000.00 | 96,660,191.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **73,186,303.00** | **141,999,052.50** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 49,766,840.95 | 96,526,504.50 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,854,915.13 | 11,418,055.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,927,407.63 | 5,677,877.50 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,927,407.63 | 5,675,183.50 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,709,731.66 | 22,701,432.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **72,415,744.14** | **75,763,192.84** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,690,222.00 | 11,544,947.00 |
| 210302 | Түлш, халаалт | 54,910,230.00 | 56,830,232.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,815,292.14 | 7,388,013.34 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **11,436,216.00** | **14,473,513.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,739,890.00 | 4,018,690.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,222,700.00 | 5,267,373.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,406,906.00 | 2,669,460.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | 1,196,100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,407,160.00 | 385,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,659,560.00 | 936,890.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **24,906,926.00** | **32,541,619.50** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 80,500.00 | 4,299,650.00 |
| 210502 | Хоол, хүнс | 23,941,026.00 | 11,963,459.50 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 885,400.00 | 16,278,510.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **13,390,725.00** | **9,332,010.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 259,100.00 | |
| 210604 | Урсгал засвар | 13,131,625.00 | 9,332,010.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **167,700.00** | **20,637,240.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 167,700.00 | 20,637,240.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **395,685,196.00** | **361,727,195.20** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 394,990,736.00 | 358,174,910.20 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 242,400.00 | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 133,400.00 | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 56,500.00 | 143,300.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 40,400.00 | 44,080.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 197,560.00 | 2,386,005.00 |
| 210807 | Газрын төлбөр | 24,200.00 | 978,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **3,896,700.00** | **90,748,340.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 67,220.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,896,700.00 | 90,681,120.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **51,730,120.56** | **130,606,819.96** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **31,973,477.00** | **7,384,800.00** |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 30,503,477.00 | 3,910,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,470,000.00 | 3,474,000.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **19,756,643.56** | **123,222,019.96** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 19,756,643.56 | 123,222,019.96 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **44,064,402.00** | **2,370,000.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **44,064,402.00** | **2,370,000.00** |
| | Дотоод эх үүсвэрээр | 44,064,402.00 | 2,370,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 44,064,402.00 | 2,370,000.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-44,064,402.00** | **-2,370,000.00** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Д/Д | Үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцоо | Дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан үр дүн | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 324,360,727.09 | 311,378,383.68 | 461,817,241.96 | 1,097,556,352.73 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 102,910,853.28 | 102,910,853.28 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 324,360,727.09 | 311,378,383.68 | 564,728,095.24 | 1,200,467,206.01 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | -102,910,853.28 | | -102,910,853.28 |
| 7 | Тайлант үеийн үр дүн | | | -123,067,300.90 | -123,067,300.90 |
| 10 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 324,360,727.09 | 208,467,530.40 | 441,660,794.34 | 974,489,051.83 |
| 17 | Тайлант үеийн үр дүн | | | 11,585,866.84 | 11,585,866.84 |
| 19 | 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 324,360,727.09 | 208,467,530.40 | 453,246,661.18 | 986,074,918.67 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО** | **1,984,251,400.00** | **1,810,881,880.04** | **173,369,519.96** | **91.26** |
| **131** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,984,251,400.00** | **1,810,881,880.04** | **173,369,519.96** | **91.26** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,984,251,400.00 | 1,810,881,880.04 | 173,369,519.96 | 91.26 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 5,000,000.00 | 5,364,700.00 | -364,700.00 | 107.29 |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,989,251,400.00** | **1,816,246,580.04** | **173,004,819.96** | **91.3** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,989,251,400.00** | **1,816,246,580.04** | **173,004,819.96** | **91.3** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,971,975,500.00** | **1,808,861,780.04** | **163,113,719.96** | **91.73** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,149,207,900.00** | **1,128,030,469.00** | **21,177,431.00** | **98.16** |
| 210101 | Үндсэн цалин | 581,403,800.00 | 649,378,245.00 | -67,974,445.00 | 111.69 |
| 210102 | Нэмэгдэл | 333,841,300.00 | 256,587,033.00 | 77,254,267.00 | 76.86 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 131,410,400.00 | 130,509,000.00 | 901,400.00 | 99.31 |
| 210104 | Урамшуулал | 102,552,400.00 | 91,556,191.00 | 10,996,209.00 | 89.28 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **139,275,300.00** | **128,050,192.50** | **11,225,107.50** | **91.94** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 94,703,800.00 | 87,041,282.50 | 7,662,517.50 | 91.91 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,146,800.00 | 10,302,145.00 | 844,655.00 | 92.42 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,570,700.00 | 5,119,922.50 | 450,777.50 | 91.91 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,570,700.00 | 5,117,228.50 | 453,471.50 | 91.86 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 22,283,300.00 | 20,469,614.00 | 1,813,686.00 | 91.86 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **80,097,800.00** | **75,763,192.84** | **4,334,607.16** | **94.59** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 21,760,800.00 | 11,544,947.00 | 10,215,853.00 | 53.05 |
| 210302 | Түлш, халаалт | 49,052,400.00 | 56,830,232.50 | -7,777,832.50 | 115.86 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,284,600.00 | 7,388,013.34 | 1,896,586.66 | 79.57 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **75,455,100.00** | **14,473,513.00** | **60,981,587.00** | **19.18** |
| 210401 | Бичиг хэрэг | 35,996,900.00 | 4,018,690.00 | 31,978,210.00 | 11.16 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 24,120,100.00 | 5,267,373.00 | 18,852,727.00 | 21.84 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,020,600.00 | 2,669,460.00 | 4,351,140.00 | 38.02 |
| 210404 | Ном, хэвлэл | 2,085,400.00 | 1,196,100.00 | 889,300.00 | 57.36 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,255,700.00 | 385,000.00 | 1,870,700.00 | 17.07 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,976,400.00 | 936,890.00 | 3,039,510.00 | 23.56 |
| **2105** | **Нормативт зардал** | **33,026,000.00** | **32,541,619.50** | **484,380.50** | **98.53** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 4,344,500.00 | 4,299,650.00 | 44,850.00 | 98.97 |
| 210502 | Хоол, хүнс | 11,964,000.00 | 11,963,459.50 | 540.5 | 100 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 16,717,500.00 | 16,278,510.00 | 438,990.00 | 97.37 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **13,303,300.00** | **10,702,010.00** | **2,601,290.00** | **80.45** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,721,300.00 | | 2,721,300.00 | |
| 210604 | Урсгал засвар | 10,582,000.00 | 10,702,010.00 | -120,010.00 | 101.13 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **29,911,100.00** | **20,637,240.00** | **9,273,860.00** | **69** |
| 210702 | Дотоод албан томилолт | 29,911,100.00 | 20,637,240.00 | 9,273,860.00 | 69 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,** | **371,018,100.00** | **318,105,203.20** | **52,912,896.80** | **85.74** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **үйлчилгээний төлбөр, хураамж** | | | | |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 367,512,100.00 | 314,552,918.20 | 52,959,181.80 | 85.59 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 217,200.00 | | 217,200.00 | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 119,600.00 | | 119,600.00 | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 143,300.00 | 143,300.00 | | 100 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 62,700.00 | 44,080.00 | 18,620.00 | 70.3 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,760,300.00 | 2,386,005.00 | -625,705.00 | 135.55 |
| 210807 | Газрын төлбөр | 978,900.00 | 978,900.00 | | 100 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 224,000.00 | | 224,000.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **80,680,900.00** | **80,558,340.00** | **122,560.00** | **99.85** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 150,000.00 | 67,220.00 | 82,780.00 | 44.81 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 80,530,900.00 | 80,491,120.00 | 39,780.00 | 99.95 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **17,275,900.00** | **7,384,800.00** | **9,891,100.00** | **42.75** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **17,275,900.00** | **7,384,800.00** | **9,891,100.00** | **42.75** |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 3,910,900.00 | 3,910,800.00 | 100 | 100 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 13,365,000.00 | 3,474,000.00 | 9,891,000.00 | 25.99 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН** | **1,989,251,400.00** | **1,816,246,580.04** | **173,004,819.96** | **91.3** |
| **2** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1** | **1** | | **100** |
| **3** | **Төсвийн байгууллага** | **1** | **1** | | **100** |
| **5** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **47** | **47** | | **100** |
| 6 | Удирдах ажилтан | 1 | 1 | | 100 |
| 7 | Гүйцэтгэх ажилтан | 40 | 40 | | 100 |
| 8 | Үйлчлэх ажилтан | 6 | 6 | | 100 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон / төгрөгөөр /

| Д/Д | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **1** | **ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО** | **180,351,692.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **180,351,692.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 129,532,200.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 50,819,492.00 |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **180,351,692.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **180,351,692.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **180,351,692.00** |

| | | |
|---|---|---|
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **111,590,840.00** |
| 210101 | Үндсэн цалин | 28,039,732.00 |
| 210102 | Нэмэгдэл | 72,087,108.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,360,000.00 |
| 210104 | Урамшуулал | 5,104,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **13,948,860.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 9,485,222.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,115,910.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 557,955.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 557,955.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,231,818.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,000,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **43,621,992.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 43,621,992.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **10,190,000.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,190,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН** | **180,351,692.00** |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа илрээгүй, нийт 3,139.4 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Зөрчлийг арилгуулах 1 төлбөрийн акт, 2 албан шаардлага хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй 3 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 3,139.4 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 29,763.7 мянган төгрөгөөс бага байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

### 3.1 Төлбөрийн акт

3.1.1 Тайлант онд 7 албан хаагчид нийт 863,659 төгрөгийн цалин хөлсийг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтад "Орон нутагт ажилласны нэмэгдлийг захиргааны албан тушаал эрхэлдэг орон нутгийн захиргааны байгууллагын төрийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 20 хувиар бодож орон нутгийн болон улсын төсвөөс сар бүр олгоно" гэж заасантай нийцэхгүй байна.

***<u>Шийдвэрлэсэн нь</u>***: Орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

### 3.2 Албан шаардлага

3.2.1 Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийг хянаж үзэхэд үлдэх өртөггүй, элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн авто тээврийн хэрэгслийн дансанд 2 ширхэг 63,500,000 төгрөг, машин тоног төхөөрөмжийн дансанд 38 ширхэг 18,724,651 төгрөг, тавилга аж ахуйн эд хогшил дансанд 40 ширхэг 3,776,189.9 төгрөг, нийт 80 ширхэг 86,000,840.9 төргийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.Тухайн хөрөнгүүдэд холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл "Эзэмшилдээ байгаа илүүдэл буюу ашиглах хугацаа дууссан, шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгах" 31.3.2 “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.2-д "Эрх бүхий байгууллагын шийдвэрээр акталж, данснаас хасахаар шийдвэрлэж, зөвшөөрөл авсан боловч ашиглалтын шаардлага хангаж байгаа, дахин ашиглах боломжтой хөрөнгийн үнийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай зөвшилцөн тогтоож, дахин данс бүртгэлд тусгана", 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 2.2.2-т “Зөвлөл нь төрийн өмчийг үрэгдүүлэх, үнэгүйдүүлэх, чанар байдлыг доройтуулах, эвдэж гэмтэх зэрэг аливаа эрсдэлээс урьдчилсан сэргийлэх, эзэмшилт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, бүртгэл, ашиглалтад хяналт тавих, үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллах үндсэн үүрэгтэй” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

***<u>Шийдвэрлэсэн нь</u>***: Өмч хамгаалах байнгын зөвлөлийг зохих ёсоор ажиллуулж зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3.2.2 Хүүхэд ,гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/64 дүгээр тушаалыг үндэслэн тус байгууллагын нягтлан бодогч 1,559,000 төгрөг, няравт 1,105,000 төгрөг нийт 2,664,000 төгрөгийг балансын урамшуулал олгосон нь төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардсан, төсвийн хөрөнгийг хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтыг зөрчсөн байна.

***<u>Шийдвэрлэсэн нь</u>***: Алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль хяналтын | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Элэгдлээрээ өртгөө нөхсөн үндсэн хөрөнгөд хуулийн дагуу арга хэмжээ аваагүй | 1 | - | | | 1 | - | | | | | | |
| Албан хаагчдын цалинг зөрүүтэй тооцсон | 1 | 863,659 | 1 | 863,659 | | | | | | | | |
| Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардсан, төсвийн хөрөнгийг хэмнэлтгүй зарцуулсан | 1 | 2,664,000 | | | 1 | 2,664,000 | | | | | | |
| **Нийт дүн** | **3** | **3,139,400** | **1** | **863,659** | **1** | **2,664,000** | | | | | | |

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*